

Бидний үүрэг хариуцлагын зам

Тэргүүлэх Бишопын Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх

Бишоп КейтБ.МкМюллин

Үүрэг хариуцлага төгс байдлыг биш, харин шаргуу хичээл зүтгэлийг шаарддаг. Энэ бол зөвхөн хуулийн дагуу байх ёстой зүйл биш, харин ариун журамт зүйл мөн. Энэ дэлхий зовлон бэрхшээл, айдас хүйдэст автжээ. Зөрчил сөргөлдөөн, гай гамшиг газар аван тэлж байна. Хүн төрөлхтөн дээсэн дөрөөн дээр дэнжигнэж байгаа юм шиг заримдаа санагдах юм.

Их Эзэн манай өнөө үеийг угтан харж, “Тэнгэр хийгээд дэлхий сэгсрэгдэх болно; мөн хүмүүний үрсийн дунд агуу гай зовлон байх болно, гэвч өөрийн хүмүүсийг би хамгаалан үлдэх болно”<sup>1</sup> гэсэн юм. Бид энэ амлалтанд агуу тайвшралыг олох учиртай билээ.

Гай гамшиг бидний “ амьдралын амар амгалан байдлыг”<sup>2</sup> үгүй болгодог ч, бидний амьдралыг үүрд мөнхөд бусниулж чадахгүй юм. Гай гамшиг бидэнд “сануулагдахын тулд”<sup>3</sup>, “Бурханы өмнө хүлээх үүргийн мэдрэмжинд биднийг сэрээж,”<sup>4</sup> “үүргийнхээ замд байхад”<sup>5</sup> тусалдаг.

Дэлхийн II Дайны үеэр Голланд улсад Каспер тен Бумийнхэн нацистуудын мөрдөн мөшгөж, авлаж байсан хүмүүст гэр орноо орогнох газар болгон ашиглуулдаг байжээ. Энэ нь Христийн шашнаа даган амьдрах тэдний нэгэн арга зам байлаа. Уг гэр бүлийн 4 гишүүн гэр орноо орогнох газар болгосны улмаас амь насаа алдсан ажээ. Коррий тен Бум, түүний эгч Бетси хоёр, Рэйвэнсбракийн бөөнөөр хорих лагерьт аймшигтай хэдэн сарыг өнгөрөөжээ. Бетси тэнд нас барж, Коррий амьд мэнд гарсан гэнэ.

Бусдыг уучлахад Бурхан бидэнд тусалдгийг Коррий, Бетси хоёр Рэйвэнсбракт байхдаа ойлгосон аж. Дайны дараа, Коррий тэрхүү захиасыг бусадтай хуваалцахаар шийдсэн гэнэ. Нэг удаа Германд, дайны гамшгаас болж зовж зүдэрсэн хэсэг

хүмүүст Бурханы өршөөлийн тухай ярьж, заажээ. Коррий тен Бум итгэлтэй байсан учир адислал ирсэн ажээ.

Нэг эрэгтэй хүн түүн уруу ойртон ирж гэнэ. Тэр хүн бөөнөөр хорих лагерийн хамгийн харгис хэрцгий харгалзагчдын нэг байсныг тэр танив. “Та яриандаа Рэйвэнсбракийг дурдлаа. Би тэнд харгалзагч байсан хүн. Гэвч тэр цагаас хойш, би Христэд итгэгч болсон. Үйлдсэн харгис муу хэргийнхээ төлөө Бурханы өршөөлийг эрэлхийлсэн гэж сайхь харгалзагч хэлээд гараа сунган, “Та намайг уучлах уу?” гэв.

Коррий тен Бум цааш нь ийн өгүүлэв: “Тэр гараа сунган зогсоод төдий их удаагүй атал надад олон цаг өнгөрөх шиг санагдаж билээ. Учир нь би урьд өмнө нь огт хийж байгаагүй хамгийн хэцүү зүйлийг хийх эсэхээ шийдэж ядан байлаа . . . Бурхан уучилдаг гэж би зааж байсан . . . Гэтэл хэцүү цаг үед бидний үйлийг үзэн тамладаг байсан хүмүүсийг уучлах ёстой байдалтай тулгараад байдаг. . . . “Надад туслаач! Би гараа өгч чадна. Би уучилж чадна. Та надад уучлах мэдрэмжийг хайрлаач” гэж би чимээгүйхэн залбиран гуйлаа.

“Би яг л хөшөө шиг, модон гартай юм шиг, гараа сунган түүнд өгч билээ. Тэр агшинд, урьд хожид тохиолдож байгаагүй нэгэн гайхамшигт зүйл тохиох нь тэр. Мөрнөөс минь эхлэн цахилгаан гүйдэл гүйх шиг болж, доошлон, бид хоёрын барьсан гаранд, бүр хурууны үзүүрт хүрэв. Яг тэр агшинд эдгэрэлтийн дулаан бүлээхэн хүч бүхэл биеэр тархаж, нүд дүүрэн нулимс цийлэгнэх нь тэр.

“Ах минь, би таныг бүх зүрх сэтгэлээрээ уучилж байна” гэж уйлан хайлан хэллээ. “Өнгөрсөн үед нэг нь шоронгийн харгалзагч, нөгөө нь хоригдол байсан бид хоёр гар гараасаа чанга барилцан удтал зогсож билээ. Тэр үед би Бурханы хайрыг урьд өмнө хэзээ ч байгаагүй ихээр мэдэрсэн юм”<sup>6</sup> хэмээн тэр ярьжээ.

Хилэнцээс зайлсхийж, Бурханы зарлигуудыг даган, гэрэлт ирээдүйн төлөө хүч чармайлт тавин тэмцдэг хүмүүсийн амьдрал зовлон зүдгүүртэй тулгарсан ч сайжрах болно. Аврагч бидэнд замыг харуулсан юм. Гетсемани, загалмай, оршуулгаас Тэрбээр ялууснаар босч ирснээр бид бүгдэд амьдрал, итгэл найдварыг авчирсан билээ. Тэрээр “ирж, намайг дага”<sup>7</sup> хэмээн биднийг урьдаг.

Ерөнхийлөгч Томас С.Монсон:

“Бид тэргүүнээ өндөрт өргөн алхаж, амьдралдаа хувь нэмрээ оруулах ёстой. Хэрвээ бид хувь тавилангаа хэрэгжүүлэн, Тэнгэр дэх Эцэгтэйгээ амьдрахаар буцаж очихыг хүсч байгаа бол Түүний зарлигуудыг дагаж, Аврагчийн амьдралын үлгэр жишээгээр амьдрах ёстой. Тэгснээр бид мөнх амьдралтай болох зорилгодоо хүрээд зогсохгүй, энэ дэлхийд *амьдрах үедээ гүйцэтгэх ёстой үүргээ сайн гүйцэтгэж, дэлхийг илүү сайн, илүү баян болгох ёстой*” гэж зөвлөжээ.<sup>8</sup>

“Энэ бүхнийг сонордоод, дүгнэхэд Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. *Энэ нь хүн бүхэнд хамаарна*”<sup>9</sup> гэсэн урам хайрласан үгс Ариун Библид байдаг.

**Үүрэг хариуцлага гэж юу вэ?** Миний энд өгүүлж байгаа үүрэг хариуцлага нь бидний хийх ёстой зүйл, харуулах ёстой зан чанар юм. Энэ бол зөв шударга, үнэн бөгөөд хүндэтгэл хүлээх зүйлсийг хувь хүмүүсээс болон нийгмээс хүсэн хүлээдэг ёс суртахууны чухал шаардлага юм. Үүрэг хариуцлага төгс байдлыг биш, харин шаргуу хичээл зүтгэлийг шаарддаг. Энэ бол зөвхөн хуулийн дагуу байх ёстой зүйл биш, харин ариун журамт зүйл мөн.

Энэ нь өндөр албан тушаалтай хүмүүст л гагцхүү хамаатай юм биш, харин хувь хүний хариуцлага, ухамсар, зоригийн үндэс суурь болдог. Үүрэг хариуцлагаа биелүүлэх нь хүний итгэлийн илрэл юм.

Ерөнхийлөгч Монсон энэ тухай: “Би *үүрэг хариуцлага* гэдэг эрхэм сайхан энэ үгийг хайрлан хүндэтгэдэг”<sup>10</sup> гэжээ. Есүс Христийн Сүмийн гишүүд бидний үүрэг хариуцлагын зам нь хийсэн гэрээнүүдээ өдөр тутмын амьдралдаа сахих явдал юм.

**Бид хэний өмнө, юуны төлөө үүрэг хариуцлага хүлээх ёстой вэ?** Бид юуны өмнө Бурхан, Мөнхийн Эцэгийн өмнө үүрэг хариуцлага хүлээдэг. Тэр бол авралын төлөвлөгөөг зохиогч, тэнгэр, газрыг бий болгогч, Адам Ева хоёрыг бүтээгч мөн.<sup>11</sup> Тэрээр үнэний эх булаг,<sup>12</sup> хайрын биет илрэл,<sup>13</sup> гэтэлгэлийн үнэн бодит шалтгаан юм.<sup>14</sup>

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит: “Бидэнд байгаа юм бүхэн [Бурханаас] ирдэг. . . . Бид өөрсдөө бол амьгүй, зуурмагийн шавар л гэсэн үг. Амьдрал, ухамсар, мэргэн ухаан, тунгаан бодох чадвар, учир шалтгаан энэ бүхэн хүмүүний үрст Бурханы өгдөг бэлэг юм. Тэрээр бидэнд бие махбодын хүч чадал, оюун ухааны чадварыг өгсөн билээ. Бид бүх оюун ухаан, хүч чадал, ухамсар, мэргэн ухаан, хүчээрээ Бурханыг хүндэтгэх хэрэгтэй. Бид дэлхий дээр сайныг үйлдэхийг эрэлхийлэх ёстой. Энэ бол бидний үүрэг хариуцлага юм” хэмээн хэлжээ.<sup>15</sup>

Бурханы Хүү, Их Эзэн Есүс Христийн төлөө үйлдэхгүйгээр Бурхан Эцэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ гэж байхгүй.. Нэгийг нь шүтэн бишрэхийн тулд нөгөөг нь мөн адил шүтэн бишрэх ёстой ажээ. Учир нь зөвхөн Христийн нэрээр болон түүгээр дамжуулан хүмүүн үүрэг хариуцлагаа бүрэн дүүрэн биелүүлж чадна хэмээн Эцэг тогтоосон юм.<sup>16</sup> Тэр бол бидэнд үлгэр дууриал үзүүлэгч, бидний Гэтэлгэгч, бидний Хаан мөн.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ бусад үүрэг хариуцлагаа ч мөн биелүүлэх ёстой. Бид бие биенийхээ төлөө, гэр бүл, Сүм, эх орныхоо төлөө өөрт нь даалгасан бүхнийг биелүүлэх үүрэг хариуцлагатай байдаг. Бид авьяас чадвараа байнга хөгжүүлдэг, хуулийг сахин биелүүлдэг, сайн иргэд байх үүрэгтэй. Бид даруухан, номхон хүлцэнгүй, хэнтэй ч хэл амаа ололцож чаддаг, нийтэч хүмүүс байх ёстой. Өөрийгөө захирч, биеэ барих чадвараар бардамналыг даван туулдаг. Дуулгавартай байдал ажилч хичээнгүй чанарыг араасаа дагуулдаг. Ийм хүмүүст амар амгалан ирдэг. Иргэд нь хүний мөс жудаг сайтай, нийгэм нь нөхөрсөг тусч болж, хөршүүд сайн найз нөхөд болдог. Тэнгэр дэх Бурхан Эцэг маань баясч ертөнц амар амгалан болж улмаар энэ дэлхий илүү сайн газар болдог юм.<sup>17</sup>

**Бид хямралын үед үүрэг хариуцлагын замаа хэрхэн мэдэх вэ?** Бид залбирдаг! Энэ нь хүн бүрийн баттай мэдэх арга зам; мөн энэ нь хүн бүрийн хувьд тэнгэртэй холбогдох арга зам юм. Төлөөлөгч Петр: “Их Эзэний мэлмий зөвт хүмүүсийн дээр байдаг. Түүний чих тэдний залбиралд анхаарал тавьдаг”<sup>18</sup> гэж хэлжээ.

Даруухан, чин сэтгэлийн, сүнслэгээр удирдагдсан залбирал бидэнд зайлшгүй хэрэгтэй тэнгэрлэг удирдамжийг боломжтой болгодог. Бригам Янг, “Заримдаа, хүмүүс будилан, санаа зоволт, айдас түгшүүрээр дүүрэн байдаг. . . ; гэвч энэ байдал нь тунгаан бодож, залбирах зэрэг бидний үүрэг хариуцлагуудыг онцгойлон сануулдаг юм.”<sup>19</sup>

Есүс ийн сургажээ:

“Та нар уруу таталтанд орохгүйн тулд сэрэмжилж, үргэлж залбирах ёстой. . . .

“Тиймийн тул та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой;. . .

“Эхнэрүүд хийгээд хүүхдүүд чинь адислагдаж болохын тулд, гэр бүлдээ Эцэгт хандан миний нэрээр үргэлж залбир.”<sup>20</sup>

Залбирал үр өгөөжтэй байхын тулд, тэнгэрийн төлөвлөгөөтэй нийцэж байх ёстой. Тийнхүү нийцсэн цагт итгэлийн залбирал үр нөлөөтэй байдаг. Бас залбирал Ариун Сүнсээр удирдагдсан үед тийнхүү нийцэн зохилдох байдлаар хангагддаг. Бидний асуух ёстой зүйл Сүнсээр өгөгдөх болно.<sup>21</sup> Энэхүү өдөөгдсөн удирдамжгүйгээр бид “Түүний хүслийг”<sup>23</sup> биш, зөвхөн өөрсдийн хүслийг эрэлхийлэн, “буруу зүйл гуйх”<sup>22</sup> болно. Залбирахдаа Ариун Сүнсээр удирдуулах нь, залбирлынхаа хариуг хүлээн авахад тэрхүү Сүнсээр гэгээрэхийн адил чухал юм. Бидний Эцэг “[бидэнд] юу хэрэгтэй байгааг гуйхаас өмнө мэддэг”<sup>24</sup> учраас тухайн залбирал тэнгэрийн адислалыг авчирдаг. Эцсийн эцэст, “Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ”<sup>25</sup> хэмээн Тэрбээр амласан билээ.

Бидний үүрэг хариуцлагын зам, Бурхан, Мөнхийн Эцэг, мөн Түүний Хүү Есүс Христ болон залбирлын хүчинд итгэх итгэл найдвараар тэмдэглэгдсэн байдгийг би гэрчилж байна. Энэ замаар Бурханд хайртай, Түүний зарлигуудыг дагахыг хүсдэг Бурханы хүүхэд бүр аялах ёстой. Залуусыг энэ нь хувийн хөгжил дэвшил, бэлтгэл өөд; насанд хүрэгчдийг шинэчлэгдсэн итгэл, шийдвэр төгс байдал өөд;

настангуудыг эцсээ хүртэл шударгаар тэвчих болон холыг харах чадвар өөд удирддаг. Энэ нь итгэлтэй аялагч бүрийг Их Эзэний хүч чадлаар зэвсэглэж, дэлхийн хилэнцээс тэднийг хамгаалж, “энэ бүхнийг сонордоод, дүгнэхэд Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна”<sup>26</sup> гэснийг ойлгох мэдлэг, ухааныг өгдөг. Есүс Христийн нэрээр, амен.

## ЭШЛЭЛ

1. Мосе 7:61; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
2. Joseph F. Smith, *Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. [1939], 156.
3. Мозая 1:17.
4. Алма 7:22.
5. Хиламан 15:5.
6. Коррий тен Бум, *Tramp for the Lord* (1974), 54-55.
7. Лук 18:22.
8. Томас С. Монсон, зөвшөөрлийг авсан болно.
9. Номлогчийн Үгс 12:13; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
10. Томас С. Монсон, “Duty Calls,” *Ensign*, 1996 оны 5 сар, 43.
11. Сургаал ба Гэрээ 20:17-19-ийг үз.
12. Сургаал ба Гэрээ 93:36-г үз.
13. 1 Иохан 4:8-ыг үз.

14. Иохан 3:16; Хиламан 5:10-11-ийг үз.

15. Жозеф Ф.Смит, Conference Report, 1899 оны 10 сар, 69,70; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.

16. Моронай 10:32-33; Сургаал ба Гэрээ 59:5-ыг үз.

17. Алма 7:23, 27-г үз.

18. 1 Петр 3:12.

19. *Teachings of Presidents of the Church: Brigham Young*, 45; (1997), 45; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.

20. 3 Нифай 18:18-19, 21.

21. Сургаал ба Гэрээ 50:29-30-ийг үз.

22. Иаков 4:3.

23. Матай 6:10.

24. Матай 6:8.

25. Матай 7:7; Судруудын Удирдамж, Иосеф Смитийн Орчуулга Матай 7:12-13-ыг үз.

26. Номлогчийн Үгс 12:13; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.